



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 09 сарын 24 өдөр

Дугаар Б/23

Модот

┌ Ур чадварын нэмэгдэл олгох тухай ┐

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.3 дахь заалт, 13 дугаар зүйл 13.3.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт, Боловсрол, Шинжлэх ухааны сайд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын хамтарсан А/35, А/10/9 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын хэмжээнд эрүүл мэндийн хичээлийн 6-12 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулагдсан массын олимпиадын 6 дугаар ангийн төрөлд 1-р байр, 9 дүгээр ангийн төрөлд 3-р байр эзэлсэн тул хими биологи, эрүүл мэндийн багш Г.Гантуяад ур чадварын нэмэгдэл олгосугай.

2. Г.Гантуяа багшид ур чадварын нэмэгдлийг 09, 10, 11 дүгээр сард үндсэн цалингийн 15%-иар тооцож олгохыг нягтлан бодогч (Л.Ариунтунгалаг)-т зөвшөөрсүгэй.

ЗАХИРАЛ



Д.ОТГОНДУЛАМ